



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 03 едер

Дугаар 8/408

Хэрлэн сум

Бруцеллёз өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны А/166 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хэмжээний малын охин төл буюу тугал, хурга, ишгийг бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлж, дархлаажуулах ажлыг 2022 оны 8 дугаар сарын 10-аас 30 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлыг сум орон нутагтаа чанартай зохион байгуулж малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нэхцэлийг бүрдүүлсэн этгээдэд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн газрын Улсын байцаагч нарт даалгасугай.

4. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Б.Сүнгээ)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ